



МОНГОЛ-ОРОСЫН
ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН НИЙГЭМЛЭГ
УЛААНБААТАР ТӨМӨР ЗАМЫН
ДАРГЫН ТУШААЛ

2016 оны 07 сарын 01 өдөр

Дугаар А-214

Улаанбаатар хот

Г Тарифын өөрчлөлтийн тухай Г

Монгол-Оросын хувь нийлүүлсэн "Улаанбаатар төмөр зам" нийгэмлэгийн дүрмийн 17 дугаар зүйлийн "в", 22 дугаар зүйлийн "а" заалт, Ерөнхий хорооны хурлын 2016 оны 5 дугаар сарын 04-ний өдрийн шийдвэрийн 2.3 дугаар заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Орон нутгийн харилцааны ачаа тээвэрлэлтийн:

2-р бүлгийн тарифыг	7%
3-р бүлгийн тарифыг	15%
4-р бүлгийн тарифыг	20%
6-р бүлгийн тарифыг	20%
9-р бүлгийн тарифыг	5%
10-р бүлгийн тарифыг	30%
11-р бүлгийн тарифыг	10%
12-р бүлгийн тарифыг	5%
13-р бүлгийн тарифыг	30%
14-р бүлгийн тарифыг	15%
15-р бүлгийн тарифыг	5%

тус тус нэмэгдүүлэн өөрчилж хавсралтаар баталсугай.

Хоёр. Энэхүү тушаалыг 2016 оны 7 дугаар сарын 11-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.


Гурав. Энэ тушаалыг хэрэгжүүлэхдээ хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд зарлах, холбогдох албадууд, ажилтнуудад тараах, зааварчилгаа өгөх, программ хангамжид зохих өөрчлөлт оруулж мөрдүүлэхийг Эдийн засаг, санхүү хариуцсан замын орлогч дарга бөгөөд Санхүү, нягтлан бодох бүртгэлийн албаны дарга /Усольцева С.Я/, Төлөвлөгөө, эдийн засгийн албаны дарга /Ё.Батбуян/, Тээврийн үйлчилгээний төвийн дарга /Ц.Хүрэлбаатар/, Статистик бүртгэл, мэдээлэл технологийн төвийн дарга /Д.Тамир/ нарт даалгасугай.

Дөрөв. Энэ тушаал гарсантай холбогдуулан УБТЗ-ын даргын 2009 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн А-52 тоот тушаал, 2009 оны 7 дугаар сарын 08-ны өдрийн А-111 тоот тушаал, 2010 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн А-198 тоот тушаал, 2015 оны 7 дугаар сарын 24-ний өдрийн А-163 тоот тушаал, 2015 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн А-258 тоот тушаалаар тус тус батлагдсан дээрх бүлгийн тарифуудыг хүчингүй болсонд тооцсугай.

002953

Тав. Энэ тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Замын нэгдүгээр орлогч дарга /Ушаков А.В/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Л.ПҮРЭВБААТАР